



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ
2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалтыг үндэслэн ТТБЗ дүгнэлтээ танилцуулж байна. Бид өргөн мэдүүлсэн төсөл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төсвийн тусгай шаардлага, 12.1, 12.3 дугаар зүйлд заасан ДХТХМ-ийн үзүүлэлтүүд болон агуулгад нийцсэн эсэх, мөн Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон төсөв боловсруулах шаардлагыг хангасан эсэхэд анхаарсан болно.

ТТБЗ-өөс төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөлд дүгнэлт өгөхдөө дараах гол чиглэлүүдийг харгалзан үзсэн. Үүнд:

- Төсвийн эрх зүйн орчныг сайжруулах, бэхжүүлэх;
- Төсвийн төлөвлөлтөд шаардагдах макро эдийн засгийн таамаглалыг бодитой байлгах;
- Монгол Улсын төсвийн бодлого нь эдийн засгийн мөчлөг сөрсөн, макро эдийн засгийн зорилго, тогтвортой өсөлтийг дэмжсэн байх;
- Төсвийн тэлэлтийг хумьж, төсвийн тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх, ДНБ-д эзлэх төсвийн орлого, зарлага, өр төлбөрийн тэнцвэртэй байлгах, төсөвт тулгарч болзошгүй эрсдэлийг бууруулах зэрэг болно.

Засгийн газраас хуулийн төсөлд өөрчлөлт оруулах гол үндэслэлээ “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр тус тус эцэслэн батлагдсанаар төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ батлагдсан дүнгээс 1 их наяд төгрөгөөр дутахаар байгаа нь төсвийн орлого, зарлага болон төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан үндсэн үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцох шаардлага үүсээд байна. Төсвийн орлогын баазыг нэмэгдүүлэх, төсвийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, ашигт ажиллагаа, санхүүгийн сахилга батыг сайжруулж, хөрөнгийн өгөөж, төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг, орлогыг нэмэгдүүлэх, төрийн өмчийн хувьцаа, хөрөнгийн удирдлагыг боловсронгуй болгох бодлогын арга хэмжээний төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцон, төсвийн орлогын шинэчилсэн тооцоонд тусгах шаардлагатай байна. Мөн Оюу Толгой төслөөс 2027 онд Монгол Улсын Засгийн газрын буюу төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос 3,000.0 тэрбум төгрөг төсөвт төвлөрөхөөр төсөөлж байгаа бөгөөд үүнээс нийгмийн өмнө тулгамдсан суурь асуудлууд болон эрчим хүч, бусад дэд бүтцийн салбарын санхүүгийн хүндрэлийг үе шаттай арилгах, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгийн дутагдлыг шийдвэрлэхээр тооцоолж байна (МУЗГ, 2026 он)” гэж тайлбарлажээ.

Нэг. Төсвийн бодлого, макро эдийн засгийн нөхцөл байдал

1.1. Бодлогын өөрчлөлт нь ДХТХМ-ийг өөрчлөх үндэслэл болжээ. Дээр дурдсанчлан Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслийн танилцуулгад макро эдийн засгийн нөхцөл байдлаас илүүтэйгээр татвар, нийгмийн даатгалын хуулиудад орсон өөрчлөлт, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг нэмэгдүүлэх зэрэг төсвийн бодлогын өөрчлөлт нь ДХТХМ-ийг өөрчлөх үндэслэл болсон байна.

1.2. ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувь хэмжээг огцом өсгөж байгаа нь Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцээгүйгээс гадна дунд орлоготой орнуудын түвшнээс давж өндөр орлоготой орнуудын түвшинд хүрсэн байна. 2025 оны 11 дүгээр сарын 28-ний өдөр УИХ-аас баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай тогтоол”-д Засгийн газрын өр, төсвийн алдагдал болон төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар бууруулахаар тусгасан байна.


Хүснэгт 1. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зарим шалгуур үзүүлэлт

Үзүүлэлт (ДНБ-д эзлэх хувь)	2024 он (суурь)	2026	2027	2028	2029	2030
Төсвийн нийт зардал	38.3	32.2	30.0	28.6	28.0	28.0
Төсвийн урсгал зардал	27.5	24.0	23.0	22.0	22.0	22.0
Засгийн газрын нийт өр	60.0	50.0	45.0	45.0	45.0	45.0

Эх сурвалж: УИХ-ын 2025 оны 109-р тогтоолын 3-р хавсралт

Өргөн мэдүүлсэн төсөлд төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувийг 2027 онд 37.8 хувь, Засгийн газрын өрийн нийт хэмжээг 50 хувьд хүргэхээр тусгасан нь таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтүүдээс харгалзан 7.8 болон 5.0 нэгж хувиар тус тус хэтэрсэн байна. Улмаар төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2026 оны байдлаар өндөр орлоготой орнуудад дунджаар 41.12, дунд орлоготой орнуудад 32.23 хувь байгаагаас үзэхэд 37.8 гэдэг нь орлогын бүлгийн дунджаас хол давсан үзүүлэлт юм.


Зураг 1. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь, орлогын бүлгийн дунджаар



Эх сурвалж: ОУВС

1.3. Эдийн засаг дахь төрийн оролцоо эдийн засгийн өсөлтийг дэмжих оновчтой түвшнээс хол зөрж байна. Эдийн засаг дахь төрийн оролцооны оновчтой түвшин, хэлбэрийг тооцох нь судалгааны чухал сэдэв бөгөөд энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг хамгийн их дэмжих төсвийн зарлагын хэмжээг тооцон гаргах боломжтой юм. Бид Монгол Улс болон ДНБ-ий хэмжээ, бүтцээрээ манайхтай ижил төстэй 26 орны 2000-2025 оны өгөгдөл дээр эконометрик шинжилгээ хийж үзэхэд “төсвийн зарлага ДНБ-ий 27 хувь байх нь өсөлтөд хамгийн их эерэг нөлөөтэй” гэсэн үр дүнд хүрсэн (Зураг 2). Өргөн мэдүүлсэн төсөлд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2027 онд 37.8 байхаар тусгасан нь дээрх критик утгаас 10.8 нэгж хувиар өндөр байна.

Зураг 2. ДНБ-ий хэмжээ ижил төстэй 27 орны төсвийн зарлага болон эдийн засгийн өсөлтийн хамаарал, 2025 оны байдлаар



Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол

Тайлбар: Албани, Азербайжан, Бангладеш, Болив, Чили, Гүрж, Гана, Гватемал, Гондурас, Киргизистан, Камбож, Молдав, Хойд Македон, Монгол, Малайз, Намиби, Никарагуа, Пакистан, Перу, Филиппин, Прагвай, Руанда, Сальвадор, Танзани, Уганда, Вьетнам

1.4. Төсвийн үзүүлэлтүүдийн таамаглал нь ТТБЗ-ийн суурь таамаглал болон ОУВС-ийн таамаглалаас зөрж байна. 2026 онд 05 дугаар сарын 29-ний өдөр баталсан ДХТХМ-д дээрх үзүүлэлтүүд ТТБЗ-ийн суурь таамаглал болон ОУВС-ийн таамаглалтай ойролцоо байсан бол энэхүү хуулийн төсөлд тусгагдсан үзүүлэлтүүд нь төсвийн орлого, зарлага болон Засгийн газрын өрийн хувьд хол зөрүүтэй байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны ТХМ-д тусгагдсан зарим үзүүлэлтийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	УИХ-аар 2026.05.29-нд баталсан 2027- 2029 оны ТХМ	ТТБЗ-ийн боловсруулсан таамаглал, 2026.03	МУЗГ, Өргөн барьсан төсөл 2026.08.30	ОУВС, Mongolia Article 4 mission statement, 2026.06
Эдийн засгийн өсөлт, хувь	5.8	5.5-5.6	5.8	5.6
Нэрлэсэн ДНБ, их наяд төг.	114.4	111.4-112.9	115.3	-
Инфляц, хувь	7.0	7.2-7.3	8.0	9.5
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэрбум төг. (ДНБ-д эзлэх хувь)	34,780.0 (30.4%)	29,855.2- 33,644.2 (26.8-29.8%)	41,280.0 (35.8%)	- (30.4%) ¹
МУНТ-ийн зарлага, тэрбум төг. (ДНБ-д эзлэх хувь)	36,493.4 (31.9%)	32,083.2- 35,902.2 (28.8-31.8%)	43,586.0 (37.8%)	(33.2%)


¹ ОУВС төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх хувийг тооцжээ.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төг. (ДНБ-д эзлэх хувь)	-1,713.4 (-1.5%)	[-2,228.0- 2,258.0] (-2%)	-2,306.0 (-2.0%)	-
Засгийн газрын өр, тэрбум төг. (ДНБ-д эзлэх хувь)	57,114.9 (50%)	47,756.7 (42.3%)	57,650.0 ² (50%)	(50.6%)

Эх сурвалж: ТТБЗ

1.5. Дунд хугацаанд инфляцын эрсдэл өндөр байна. Газрын тос болон бусад өргөн хэрэглээний бүтээгдэхүүний импортын үнийн өсөлт, төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөр өдөөгдөн 2027 оны 1-р хагаст инфляц өсөх, улмаар 2027 оны 2-р хагаст үргэлжлэх өндөр магадлалтай байна.

Зураг 3. Монгол Улсын төсвийн зарлага, инфляцын хамаарал



Нөгөө талаас ДХТХМ-ийн төсөлд тусгагдсан төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 37.8-31.2 байгаа нь Колин Кларкийн критик хязгаарыг давсан хэвээр байна³.


1.6. Эдийн засгийн хувьд эрсдэл учрахаар байгааг анхаарах шаардлагатай байна. 2026 оны эхний хагаст эдийн засгийн өсөлт 7.7 хувьтай гарсан ч энэ өсөлт оны эцэст хадгалагдах эсэх нь эргэлзээтэй байна. Учир нь, энэхүү өсөлтийн дийлэнх уул уурхайн салбар, түүний нөлөөллөөр бий болсон тээврийн салбарын өсөлтөөр дэмжигдсэн боловч үйлчилгээний салбарын агшилт, ХАА-н салбарын суурийн нөлөө, дэлхийн уур амьсгалд учирч буй Эл Нино гэх мэт гоц үзэгдэлтэй холбоотойгоор буурах хандлагатай байна.

1.7. Төсвийн зарлагын өсөлтөд сонгуулийн циклийн нөлөөлөл ажиглагдаж байна. Монгол Улсын 2000-2025 оны төсвийн зарлагын үзүүлэлтүүдэд эконометрик, статистик аргаар дүн шинжилгээ хийхэд УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулдаг жилүүдэд төсвийн зарлага илүү өсөх хандлагатай байгаа бөгөөд энэхүү сул эерэг хамаарлаас шалтгаалан сонгууль төсвийн зарлагын өсөлтөд нөлөөгүй гэсэн таамгийг статистикийн аргачлалаар няцааж чадахгүй байна.

² Монгол Улсын 2027 оны төсвийн танилцуулгад 56,628.7 тэрбум төгрөг гэснээс зөрүүтэй байна.

³ Английн эдийн засагч Колин Кларк ДНБ-д эзлэх төсвийн зардал 25%-аас дээш гарсан үед төсөв баланстай байсан ч инфляцыг өдөөдөг болохыг 1945 онд судлан тогтоожээ. Монгол Улсад 1997 оноос эхлэн төсвийн зардал Кларкийн хязгаарыг тогтмол давсан байдалтай байв. Colin Clark, "Public Finance and Changes in the Value of Money", *The Economic Journal*, Vol. 55, No. 220 (December 1945), pp. 371–389.


Зураг 4. Төсвийн нийт зарлагын өсөлтөд сонгуулийн циклийн үзүүлэх нөлөө



Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол

Сонгуулийн жилд нийт зарлагын өсөлт 3.2 хувиар нэгж хувиар нэмэгдсэн байна.


Зураг 5. Төсвийн урсгал зардлын өсөлтөд сонгуулийн циклийн үзүүлэх нөлөө



Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол

Сонгуулийн жилд урсгал зардлын өсөлт 3.2 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Зураг 6. Төсвийн цалин хөлсний өсөлтөд сонгуулийн циклийн үзүүлэх нөлөө




Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол

Сонгуулийн жилд цалин хөлсний зардлын өсөлт 13.2 нэгж хувиар нэмэгдсэн байна.

1.8. Төсвийн орлогын өсөлтийг дагуулан нийт зарлагыг өсгөснөөс үүдэн Тогтворжуулалтын санд төвлөрөх боломжит орлого буурав. 2027 онд татварын бус орлогоор бүрдүүлэхээр төсөөлж буй 6.5 орчим их наяд төгрөгийн нэмэгдэл нь төсвийн зарлага 2026 оны 5 дугаар сарын 29-ны өдөр батлагдсан 36.5 их наяд төгрөг хэвээр үлдсэн тохиолдолд тэнцвэржүүлсэн тэнцлийн ашгийг 4.7 их наяд төгрөгт хүргэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.2.2-т зааснаар Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого болох зохицуулалттай байна.

1.9. Төсвийн орлогын бүтцэд гарч буй өөрчлөлт нь олон улсын жишигт нийцэж байна. Өмнөх жилүүдэд төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнгийн 90 орчим хувийг татварын орлого, 10 орчим хувийг татварын бус орлого бүрдүүлж ирсэн бол 2027 онд энэ үзүүлэлт харгалзан 80:20 орчим хувь болж өөрчлөгдсөн нь төсвийн орлогын бүтцэд гарч буй гол өөрчлөлт болж байна.


Зураг 7. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020-2027 оны тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн (татварын ба татварын бус орлогоор ангилсан), тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн танилцуулга

2025 оны байдлаар дэлхийн 144 оны өгөгдлөөс үзэхэд төсвийн орлогод татварын орлогын эзлэх хувь дунд орлоготой орнуудын хувьд 70-71, өндөр орлоготой орнуудын хувьд 80 байна. Энэ хувь баялгийн эдийн засагтай орнуудын хувьд илүү доогуур байдаг ажээ.

Зураг 8. Нийт орлогод татварын орлогын эзлэх хувь



Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол

Хоёр. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэх

А. Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй төсвийн тусгай шаардлагыг хангаж буй эсэх

2.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Өргөн мэдүүлсэн төсөлд 2027 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тн тутамд 10,249.9 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тн тутамд 125.4 ам.доллар байхаар төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.3-т заасан тодорхойлолтын дагуу тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон гэж үзэх үндэслэл болж байна.


2.2. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байх. Хуулийн төсөлд энэхүү шаардлагыг хангасан эсэх талаарх мэдээлэл, тооцоолол тусгагдаагүй тул энэ талаар дүгнэлт өгөх боломжгүй байна.

2.3. Засгийн газрын өрийн нийт хэмжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2027-2029 онд хуульд заасан хязгаарт буюу харгалзан 50, 50, 45 хувь байхаар тооцоолжээ.

2.4. Урсгал зардал. Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн урсгал зардлыг 33,583.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд уг дүн нь тухайн жилийн ДНБ-ий 29.1 хувьтай тэнцэж байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан нэгдсэн төсвийн урсгал зарлага тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагаас 0.9 нэгж хувиар доогуур байна.

Б. Засгийн газраас 2026.08.20-нд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгагдсан төсвийн тусгай шаардлагыг хангаж буй эсэх

Зураг 7. Эрдэс баялгийн бус ДНБ-ий нэрлэсэн өсөлтийн таамаглал



Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол.

2.5. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ. Нэгдсэн төсвийн нийт зарлага 2027 онд 28.2 хувиар өсөхөөр тусгасан нь 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Засгийн

газраас өргөн мэдүүлсэн “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд “нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт болон өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” шаардлагыг хангахгүй байна.

2.6. Тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-т “2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2027-2029 онуудад ДНБ-ий -2.0, -1.5, -1.0 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангасан байна.

В. Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн бусад заалтыг хэрэгжүүлсэн байдал

2.9. Олон нийтийн хэлэлцүүлэг. Төсвийн тухай хуулийн 28¹.4-т “Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олон нийтийн хэлэлцүүлгийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд энэ зүйлд заасан журмаар зохион байгуулна”, ТТБТ хуулийн 12.3.10-т “олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгасан талаарх мэдээлэл” гэсэн заалтын дагуу хэлэлцүүлэг явуулсан үр дүнг төслийн танилцуулгад хавсралтаар тусгасан нь хуулийн заалтыг хэрэгжилтийг хангасан гэх үндэслэл болж байна.

2.10. Төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга сайжирч байгаа ч зарим тоон мэдээлэл зөрүүтэй байгааг анхаарах шаардлагатай байна. Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгын Хүснэгт 1 дээрх 2025 болон 2026 оны эдийн засгийн өсөлтийн тоон мэдээг алдаатай оруулсан, Хүснэгт 3.2 дээрх төсвийн тэнцвэржүүлсэн орлого нь Хүснэгт 4.3 буюу өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгагдсан дүнгээс зөрсөн зэрэг алдаатай байна.

2.11. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулах өөрчлөлт нь төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах нөлөөтэй хэмээн үзэж байна. Уг хуулийн төслийг дагалдах хуульд “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн 7-р зүйлд “7.9.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсанаас хойш уг мэдэгдлийг боловсруулахад тооцох боломжгүй нөхцөлөөс шалтгаалан ногдол ашгийн орлого, орон нутгийн үнэт цаас, урьд оны үлдэгдлээс хамаарсан эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого уг мэдэгдэлд тусгасан доод хэмжээнээс нэмэгдэхээр бол тухайн ногдол ашгийн орлого, эх үүсвэрээс шалтгаалсан нэмэгдлийн хэмжээгээр энэ хуулийн 12.1.4-т заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэн тооцож, болно. Энэ тохиолдолд уг нэмэгдлийн хэмжээнд энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлага хамаарахгүй. Энэ хуулийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө” гэсэн заалт оруулахаар тусгасан.

Өргөн мэдүүлсэн төсөлд энэ хуулийн үзэл баримтлалыг тусгаагүйгээс гадна энэ зохицуулалт нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйл (Төсвийн зарчим)-ийн

- 5.1.1.төсвийн тогтвортой байдлыг хангасан байх,
- 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх,
- 5.1.4.хариуцлагатай байх

зарчмуудын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхөөр байна. Улмаар 2026 оны 08 дугаар сарын 20-нд төсвийн тодотголыг дагуулан Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд тусгагдсан төсвийн тусгай шаардлага буюу зарлагын шинэ дүрмийг шууд зөрчих нөхцөлийг бүрдүүлж, төсвийг хяналтгүй тэлэх үүд хаалгыг нээх эрсдэлтэй хэмээн үзэж байна.

Гурав. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж

3.1. Төсвийн эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах шаардлагатай байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (2010) батлагдсанаас хойш 22 удаа өөрчлөгджээ. ДХТХМ нь төсвийг дагаж өөрчлөгддөг байсныг хязгаарлах хуулийн зохицуулалт (ТТБТХ, 7.5-р заалт) 2025 оноос мөрдөгдөж эхэлсэн ч тус хуулийн 2026 оны 08 дугаар сарын 20-нд өргөн мэдүүлсэн өөрчлөлтөөр энэхүү заалтыг хүчингүй болгож, 2027 оны ДХТХМ-д дахин өөрчлөлт оруулж байна. Энэ байдлыг цаашид давтахгүй байх нь төсвийн тогтвортой байдал хадгалагдах, эрсдэл буурахад эергээр нөлөөлнө. Үүнийг хэрэгжүүлэх гол үндэс нь үндэслэл бүхий сайн тооцоо, судалгаанаас гадна эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг тэлэлт, агшилтын мөчлөг ялгалгүйгээр хэрэгжүүлж, орлогын өсөлтийг дагаж зардлын хэт тэлэлтийг бий болгохгүйгээр хуримтлал үүсгэх, эдийн засаг хүндэрсэн үед зарлагыг хэт танахгүйгээр санхүүжүүлэх боломжтой байх явдал юм. Мөн хууль дээдлэх зарчмыг тууштай мөрдөх, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай болон бусад хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийг өөрчлөх бус, нийцүүлэх зарчмыг мөрдлөг болгох шаардлагатай байна.

3.2. Голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийн төсөөлөл зах зээлийн нөхцөл байдлыг үл харгалзан өндөр хэвээр байна. Нэгдсэн төсвийн 2026 оны ДХТХМ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 2027 онд 125.4 ам.доллар байхаар, харин зах зээлийн үнийг 68 ам.доллар байхаар тооцжээ. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцохдоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3.а-д заасны дагуу “... Олон улсын валютын сангаас гаргасан түүхий эдийн үнийн статистикт тусгасан тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах 20, 19, 18 жилийн дундаж үнэ, эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас тухайн жилийн гуравдугаар сард анх зарласан өдрийн тухайн төсвийн жилийн болон түүний дараах гурван жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцох” мөн хуулийн 11.1.3.б-д заасны дагуу “... гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийн тооцоонд алтны тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах жилүүдийн дундаж үнийг тусгахдаа эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас гаргасан статистикт тусгасан үнийн дунджаар тооцох” хуулийн зохицуулалттай байгаа нь зарим жилүүдэд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ бодит үнээс хэт ялгаатай тогтох нөхцөлийг бүрдүүлж байна.

3.3. ДХТХМ-ийн үзүүлэлтүүд дутуу, буруу томъёололтой хэвээр байна. 2010-2025 оны хооронд Төсвийн тухай хуульд 71 удаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 22 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан нь эдгээр хуулиудын хоорондын уялдаа, нэгдмэл байдал болон зохицуулах чадварт нь сөргөөр нөлөөлж, төсвөө төсвийн хүрээ нь дагадаг, тодотгол хийн төсвийн орлого, зарлага буурсан үед ч хүрээ нь хөндөгддөг нөхцөлд хүрсэн байна. Иймээс эдгээр хуулийн нийцлийг эргэн харж тодорхой өөрчлөлт оруулах шаардлага үүссэн байна. Тухайлбал, дараах үзүүлэлтийг ДХТХМ-д тусгаж байх нь зүйтэй байна (Хүснэгт 4).

Хүснэгт 3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ордоггүй, төсвийн төлөвлөлт болон тусгай шаардлагуудад шууд хамааралтай үзүүлэлтүүд

ДХТХМ-д багтаагүй үзүүлэлтүүд	ДХТХМ-д багтаах үндэслэл
Нэрлэсэн ДНБ	Төсвийн тусгай шаардлагууд нэрлэсэн ДНБ-д эзлэх хувиар илэрхийлэгдэн хуульчлагдсан.
Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардал	Төсвийн тусгай шаардлагад туссан.
Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого	Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, бодлогын бичиг баримтад тусгагддаг.
Эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт	Засгийн газраас 2026 оны 8 сарын 20-нд өргөн мэдүүлснээр төсвийн тусгай шаардлагад тусгагдахаар болсон.

3.4. ДХТХМ-д өөрчлөлт оруулах зохицуулалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд хангалттай тусгаагүй байна. ДХТХМ-д өөрчлөлт оруулах тохиолдолд хуулийн төслийг өргөн барихдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.6-д “Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг энэ хуулийн 16¹.5.1-д⁴ заасан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулаагүй бол түүний үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлж тайлбарлан, уг тайлбарыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн хамт өргөн мэдүүлнэ” гэснийг баримтлах эсэх нь тодорхойгүй, нарийвчилсан зохицуулалтгүй байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ
2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

⁴ 16¹.5.1 дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал боловсруулах